

2022 оны 4 сарын 4 өдөр

Дугаар: 03/02

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ДҮРМИЙН ШИНЭЧИЛСЭН  
НАЙРУУЛГЫГ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.1 заалт, 2022 оны 4 сарын 04-ний өдрийн тооллогын комиссын 02/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн албан ёсны хаягийг Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж, Pearl Tower 1101 тоот өрөө болгон өөрчилсүгэй.
2. Компанийн оноосон нэрийг хавсралтад баталгаажуулсан хуулийн этгээдийн бүртгэлийн газрын нэрийн баталгаажуулалтын хуудсанд заасны дагуу өөрчилсүгэй.
3. Компаний үйл ажиллагааны чиглэлд бизнесийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ, ESG advisory Environmental, Social, and Governance/, хиймэл оюун ухааны зөвлөх үйлчилгээ, мэдээлэлийн технологийн үйлчилгээг нэмж аван бүртгүүлсүгэй.
4. Компанийн дүрмийн шинэчилсэн энэ найруулгыг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



М.САЙНБОЛОР

2022 оны 4 сарын 04 өдөр

Дугаар: 03/04

Улаанбаатар хот

**ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.10 заалт, 2022 оны 4 сарын 04-ний өдрийн тооллогын комиссын 02/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани цаашид ногоон хөгжил, хиймэл оюун ухаан, мэдээлэлийн технологи программ хангамжид суурилсан бизнес явуулахаар төлөвлөж байгаа тул гадны хөрөнгө оруулагч болон хөрөнгө оруулалтын сангаас хоёр тэрбум төрөг хүртлэх зээлийг одоогийн банкны зээлийн хүүнээс хэтрүүлэлгүйгээр авахыг зөвшөөрсүгэй.
2. Өргөн цар хүрээгээр үйл ажиллагаа явуулах гэж байгаатай холбогдуулан мэдлэг чадвартай мэргэшсэн боловсон хүчин, компанитай олон жилийн хугацаатай их хэмжээний хэлцэл байгуулахыг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



М.САЙНБОЛОР

2022 оны 4 сарын 4 өдөр

Дугаар: 03/03 Улаанбаатар хот

**НОГДОЛ АШИГ ХУВИАРЛАХГҮЙ  
ТУХАЙ ШИЙДВЭРИЙГ ТАЙЛАГНАХ НЬ**

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.6-р заалтууд, 2022 оны 4 сарын 04-ний өдрийн тооллогын комиссын 02/02 дугаар тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компани нь ашигтай ажиллаагүй тул ногдол ашиг хувиарлахгүй гэж шийдвэрлэсэн тухай хувьцаа эзэмшигч нарт тайлагнасан болохыг дурьдсугай.

ХУРЛЫН ДАРГА



М.САЙНБОЛОР

**silknet**∞

Network. Partnership. Representation

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ  
“СИЛК НЭТ” ХК**

2022 оны 4 сарын 4 өдөр

Дугаар: 03/01

Улаанбаатар хот

**ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ, ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дэх заалт, 2022 оны 4 сарын 04-ний өдрийн тооллогын комиссын 02/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бизнес төлөвлөгөө болон компанийн үйл ажиллагааг цаашид хэвийн явуулахад шаардлагатай бусад төсөл төлөвлөгөөг батлан зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



М.САЙНБОЛОР